



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 345

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын албан тушаалд
томилохыг зөвшөөрөх тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.1, “Компанийн тухай хууль”-ийн 84.1, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 34.1.1, 34.1.4 Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 10.1, 10.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Стандарт инвестмент” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Чулуунтулга овогтой Жаргалыг томилохыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 251 дүгээр тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллахыг “Стандарт инвестмент” ХХК /Ч.Жаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

030.35